



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

“Шилдэг гудамж” шалгаруулах
болзолт уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 25 дугаар зүйлийн 25.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн 7-24 дүгээр хороодын хэмжээнд “Шинэ Чингэлтэй - Цэмцгэр орчин, эрүүл амьдрал” уриан дор “Шилдэг гудамж” шалгаруулах болзолт уралдааныг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Шилдэг гудамж шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү уралдааныг хороодын түвшинд зохион байгуулах, иргэдийг өргөнөөр оролцуулах, олон нийтийн санаачилгыг дэмжих ажлыг зохион байгуулахыг хороодын Засаг дарга нарт, арга зүй, нэгдсэн зохион байгуулалтаар ханган, дүнг нэгтгэн танилцуулахыг Засаг даргын Орон тооны зөвлөх (Д.Уянга)-д тус тус үүрэг болгосугай.

4.Уралдааныг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525100675